



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/309

Улаанбаатар хот

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1.17 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 188, 30, 39 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/616 дугаар захирамж, Улсын Онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал сунгаж байгаатай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих ажлыг зохион байгуулсугай.

2. Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд албан хаагчид, үйлчлүүлэгчдийг гараа халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангах, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, дотооддоо цэвэрлэгээний ажлыг тогтмол зохион байгуулах, ариутгал халдваргүйтгэлийн тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэлийн үйлчилгээг тогтмол хийлгэх арга хэмжээ авч ажиллахыг худалдаа, үйлчилгээний байгууллагуудын захиргаанд даалгасугай.

3. Хяналт шалгалтад шаардагдах зардлыг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газрын дарга /Д.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс /Э.Сансар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА